



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/12

Мандагловь

"Эйбл" системийн ашиглалт,
үйлчилгээний зардал олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23/27 дугаар хамтарсан тушаал, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 01 дүгээр 25-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 01/58 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн ажилтны мэдээллийн сангийн ашиглалт, үйлчилгээний чанарыг сайжруулах, тасралтгүй хэвийн явуулах боломжийг хангах зорилгоор "Эйбл" системийн үйлчилгээний зардлыг баталсугай.

2. Зардалд шаардагдах 500,000 (Таван зуун мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн (Р.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

• 482201041